



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 14095

Булган

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.1, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2017 оны VI хуралдааны 06/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын нутаг дэвсгэр дэх эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт буулгах ажилд шаардлагатай шатахууны зардлыг “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг зохион байгуулах ажлын зардлаас гаргасугай.

2. Дээрх ажлыг чанартай сайн зохион байгуулж ажиллахыг Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн дарга /Н.Баасанжаргал/, хяналт тавьж ажиллахыг Булган сумын Засаг дарга /Д.Наранбаяр/ нарт тус тус даалгасугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1753095 /нэг сая долоон зуун тавин гурван мянга ерэн тав/ төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ